

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/48/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 9935-2099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2025.02.25 № 87

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Дархан-Уул аймгийн ИТХ-ын хөрөнгө оруулалтаар 8,690.6 мянган төгрөг, Шарын голын ЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар 8,300.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, Тогтвортой амжиргаа төслийн хөрөнгө оруулалтаар 3,323.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,162.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Орон нутгийн хөгжлийг дэмжих төслийн Шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтаар 87,902.3 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө /хүлэмж, усалгааны систем/-ийг үнэ төлбөргүй хүлээн авч, ОНӨГ-ын даргын 2024 оны А/34 тушаалаар 13,500.0 мянган төгрөгийн Цагдаагийн газрын явуулын ажлын байрыг шилжүүлэн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 281,348.9 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 28.6 хувиар өссөн байна

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 31 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн хагас жил бүр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,577,000.00	444,500.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,005,100.00	
312	Банканд байгаа бэлэн мөнгө	3,005,100.00	
3121	төгрөг	3,005,100.00	
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	1,571,900.00	444,500.00
351	Түүхий эд материал		
354	Хангамжийн материал	1,571,900.00	444,500.00
35410	Бичиг хэргийн материал	84,500.00	84,500.00
35420	Аж ахуйн материал	1,487,400.00	360,000.00
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,396,182,655.82	1,457,738,998.08
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,396,182,655.82	1,457,738,998.08
392	Биет хөрөнгө	1,097,192,655.86	1,177,078,998.08
39201	Барилга, байгууламж орон сууц	971,253,854.45	971,253,854.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43,363,742.69)	(58,663,798.01)
39203	Авто тээврийн хэрэгсэл	60,763,000.00	77,753,645.10
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,082,594.62)	(27,999,911.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	87,819,335.00	81,395,135.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,428,472.77)	(41,507,250.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,137,400.00	11,842,324.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,421,776.58)	(4,906,702.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	90,505,979.00	191,908,417.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,160,325.93)	(24,166,716.77)
39217	Ном	170,000.00	170,000.00
393	Биет бус хөрөнгө	298,989,999.96	280,660,000.00
39301	Программ хангамж	20,990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,000,000.04)	(330,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	280,000,000.00	280,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,400,759,655.82	1,458,183,498.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,005,100.00	
413	Өглөг	3,005,100.00	
4136	Бусад өглөг	3,005,100.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,005,100.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,397,754,555.82	1,458,183,498.08
51	Засгийн газрын хувь оролцоо	1,397,754,555.82	1,458,183,498.08

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	294,101,027.46	294,101,027.46
51101	Өмч: - төрийн	1,103,653,528.36	338,021,469.41
512	Хуримтлагдсан үр дүн	1,103,653,528.36	1,164,082,470.62
51210	Өмнөх үеийн үр дүн		1,103,653,528.36
51220	Тайлант үеийн үр дүн		60,428,942.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,400,759,655.82	1,458,183,498.08



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	563,312,475.96	762,112,452.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,940,175.96	336,384,252.55
120	Нийтлэг татварын бус орлого	108,946,530.90	336,384,252.55
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	108,946,530.90	213,504,843.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,946,530.90	209,044,563.92
1200045			4,460,280.00
120009	Бусад орлого	990,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	60,003,645.06	122,879,408.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,372,300.00	425,728,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,750,100.00	3,678,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	62,750,100.00	3,678,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	320,622,200.00	422,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	320,622,200.00	422,050,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	533,395,776.73	665,780,569.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,395,776.73	665,780,569.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338,579,053.35	406,827,476.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,729,573.12	281,348,920.31
210101	Үндсэн цалин	123,863,574.45	162,468,850.13
210102	Нэмэгдэл	63,216,155.83	90,804,470.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,648,000.00	12,178,000.00
210104	Урамшуулал	23,001,842.84	15,897,600.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,299,594.73	35,101,296.02
210201	Тэтгэврийн даатгал	18,338,207.39	23,896,482.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,239,736.41	2,809,313.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,750,281.81	1,422,832.12
210204	Ажилгүйдлийн даатгал	357,073.59	1,394,126.84
210205	Эрүүл мэндийн даатгал	3,614,295.53	5,578,540.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,962,897.01	4,481,433.74
210301	Гэрэл, цахилгаан	2,170,171.02	1,582,345.82
210302	Түлш, халаалт	3,792,725.99	2,899,087.92
210303	Цэвэр, бохир ус		
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	15,298,509.66	11,473,520.80
210401	Бичиг хэрэг	5,048,000.00	3,951,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,659,000.00	4,200,000.00



210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,654,070.66	1,328,606.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	937,439.00	1,993,414.00
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал		
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		500,000.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		500,000.00
210604	Урсгал засвар		
2107	Томилолт, зочны зардал	13,752,000.00	11,622,000.00
210702	Дотоод албан томилолт	13,752,000.00	11,622,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,567,733.00	13,143,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,640,500.00	5,177,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	550,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	641,000.00	
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ		7,116,000.00
210807	Газрын төлбөр	736,233.00	300,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,968,745.83	49,156,805.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	834,000.00	679,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,134,745.83	48,477,805.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,816,723.38	258,953,093.05
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,093,400.00	27,525,164.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,671,200.00	3,005,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,622,200.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		23,170,064.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,350,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	173,723,323.38	231,427,929.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,973,223.38	227,749,729.05
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэн шилжүүлэг	62,750,100.00	3,678,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,451,044.23	96,331,882.66
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,440,675.06	35,902,940.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,440,675.06	34,555,540.40
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1,347,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(19,440,675.06)	(35,902,940.40)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,010,369.17	60,428,942.26




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	502,318,830.90	634,772,763.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,946,530.90	209,044,563.92
120	Нийтлэг татварын бус орлого	108,946,530.90	209,044,563.92
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,946,530.90	209,044,563.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,372,300.00	425,728,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,750,100.00	3,678,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	10,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	62,750,100.00	3,678,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	320,622,200.00	422,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,622,200.00	422,050,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	482,923,730.90	617,522,763.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,923,730.90	617,522,763.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,444,307.52	358,569,670.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	218,729,573.12	278,125,197.76
210101	Үндсэн цалин	118,216,798.17	159,679,618.45
210102	Нэмэгдэл	68,914,817.04	90,509,787.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,667,928.83	12,078,192.04
210104	Урамшуулал	22,930,029.08	15,857,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,299,594.73	38,325,018.57
210201	Тэтгэврийн даатгалын	18,390,094.13	26,867,865.73
210202	Тэтгэмжийн даатгалын	2,187,851.26	3,031,390.75
210203	ҮОМШӨ-ий даатгалын	1,750,282.35	1,404,656.84
210204	Ажилгүйдлийн даатгалын	357,070.69	1,394,126.84
210205	Эрүүл мэндийн даатгалын	3,614,296.30	5,626,978.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,962,897.01	4,481,433.74
210301	Гэрэл, цахилгаан	2,170,171.02	1,727,895.35
210302	Түлш, халаалт	3,792,725.99	2,753,538.39
210303	Цэвэр, бохир ус		
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материал	15,298,509.66	11,473,520.80
210401	Бичиг хэргийн зардал	4,988,500.00	3,951,500.00
210402	Тээвэр шатахуун	7,659,000.00	4,200,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,654,070.66	1,328,606.80
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	996,939.00	1,993,414.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил урсгал засвар	-	720,000.00
210601	Багаж техник хэрэгсэл		720,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,752,000.00	11,622,000.00
210702	Дотоодын томилолт	13,752,000.00	11,622,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	9,567,733.00	13,143,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,640,500.00	4,927,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	550,000.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	641,000.00	7,366,000.00
210807	Газрын төлбөр	736,233.00	300,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	834,000.00	679,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	834,000.00	679,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,479,423.38	258,953,093.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,756,100.00	27,525,164.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	333,900.00	3,005,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	16,622,200.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг		23,170,064.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,800,000.00	1,350,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	173,723,323.38	231,427,929.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,973,223.38	227,749,729.05
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	62,750,100.00	3,678,200.00
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	19,395,100.00	17,250,000.00
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	16,390,000.00	17,250,000.00
		0	16,390,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(16,390,000.00)	(17,250,000.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3,005,100.00	(0.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,005,100.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,005,100.00	



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Лөгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	294,101,027.46		1,095,310,929.19	-	1,389,411,956.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,101,027.46	-	1,095,310,929.19	-	1,389,411,956.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			8,342,599.17		8,342,599.17
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,101,027.46	-	1,103,653,528.36	-	1,397,754,555.82
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,101,027.46	-	1,103,653,528.36	-	1,397,754,555.82
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			60,428,942.26		60,428,942.26
D07	Тайлант үеийн үр дүн			1,164,082,470.62		1,458,183,498.08
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,101,027.46				




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	526,885,400.0	403,344,834.9	(123,540,565.1)	76.6%
21	Урсгал зардлын дүн	526,885,400.0	386,094,834.9	(140,790,565.1)	73.3%
210	Бараа үйлчилгээний зардал	498,480,300.0	358,569,670.9	(139,910,629.1)	71.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,134,800.0	278,125,197.8	(96,009,602.2)	74.3%
210101	Үндсэн цалин	178,702,500.0	159,679,618.5	(19,022,881.6)	89.4%
210102	Нэмэгдэл	163,267,400.0	90,509,787.3	(72,757,612.7)	55.4%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,784,000.0	12,078,192.0	(2,705,808.0)	81.7%
210104	Урамшуулал	17,380,900.0	15,857,600.0	(1,523,300.0)	91.2%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	0.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,766,900.0	38,325,018.6	(8,441,881.4)	81.9%
210201	Тэтгэврийн даатгал	31,801,500.0	26,867,865.7	(4,933,634.3)	84.5%
210202	Тэтгэмжийн даатгал	3,741,300.0	3,031,390.8	(709,909.3)	81.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,870,700.0	1,404,656.8	(466,043.2)	75.1%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,870,700.0	1,394,126.8	(476,573.2)	74.5%
210205	ЭМД-ын хураамж	7,482,700.0	5,626,978.4	(1,855,721.6)	75.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,504,500.0	4,481,433.7	(8,023,066.3)	35.8%
210301	Гэрэл, цахилгаан	6,753,300.0	1,727,895.4	(5,025,404.7)	25.6%
210302	Түлш, халаалт	4,522,300.0	2,753,538.4	(1,768,761.6)	60.9%
210303	Цэвэр, бохир ус	1,228,900.0	-	(1,228,900.0)	0.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	12,530,000.0	11,473,520.8	(1,056,479.2)	91.6%
210401	Бичиг хэрэг	4,000,000.0	3,951,500.0	(48,500.0)	98.8%
210402	Тээвэр шатахуун	4,200,000.0	4,200,000.0	-	100.0%
210403	Шуудан холбоо	2,330,000.0	1,328,606.8	(1,001,393.2)	57.0%
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	2,000,000.0	1,993,414.0	(6,586.0)	99.7%
2105	Нормативт зардал	-	-	-	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,300,000.0	720,000.0	(18,580,000.0)	3.7%
210601	Багаж хэрэгсэл	7,400,000.0	720,000.0	(6,680,000.0)	9.7%
210602	Тавилга	11,900,000.0	-	(11,900,000.0)	0.0%
2107	Томиллолт, зочны зардал	14,262,100.0	11,622,000.0	(2,640,100.0)	81.5%
210702	Дотоод томиллолт	14,262,100.0	11,622,000.0	(2,640,100.0)	81.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	16,982,000.0	13,143,500.0	(3,838,500.0)	77.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,250,000.0	4,927,500.0	(2,322,500.0)	68.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.0	550,000.0	(200,000.0)	73.3%
210803	Даатгалын үйлчилгээ	110,000.0	-	(110,000.0)	0.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.0	-	(150,000.0)	0.0%
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	-	(22,000.0)	0.0%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,500,000.0	7,366,000.0	(134,000.0)	98.2%
210807	Газрын төлбөр	1,200,000.0	300,000.0	(900,000.0)	25.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0	679,000.0	(1,321,000.0)	34.0%



210901	Бараа үйлчилгээний бусад зардал		-	-	0.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.0	679,000.0	(1,321,000.0)	34.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,405,100.0	27,525,164.0	(879,936.0)	96.9%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	0.0%
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг		-	-	0.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,405,100.0	27,525,164.0	(879,936.0)	96.9%
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	3,005,100.0	3,005,100.0	-	100.0%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,900,000.0	23,170,064.0	(729,936.0)	96.9%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,500,000.0	1,350,000.0	(150,000.0)	90.0%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	-	0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	-	0.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	17,250,000.0		
	Дотоод эх үүсвэрээр		17,250,000.0		
	Тоног төхөөрөмж		17,250,000.0		
	Бусад хөрөнгө		-		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	526,885,400.0	403,344,834.9		76.6%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	526,885,400.0	191,800,326.3		36.4%
132001	Орон нутгийн төсвөөс	526,885,400.0	191,800,326.3		36.4%
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	211,544,508.6		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		211,544,508.6		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	3,005,100.00		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	-		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100%
3	Төсвийн байгууллага	1	1	-	100%
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	10	-	83%
	Удирдах ажилтан	1	1	-	100%
	Гүйцэтгэх ажилтан	11	9	-	82%
	Үйлчлэх ажилтан	-	-	-	-



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн өмчийн талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, үр ашигтай зохион байгуулахад оршино. Орон нутгийн өмчийн газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан зорилтыг ханган ажилласан байна.

Орон нутгийн өмчийн харилцааны чиглэлээр:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн өмчийн харилцааны чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж, түүний хэрэгжилтийг ханган ажиллах,
- Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, үр ашигтай ажиллуулахад хяналт тавьж орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх,
- Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэхэд бүртгэлээр хяналт тавих,
- Орон нутгийн өмчийн Улсын үзлэг, тооллогыг тухайн жилд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, нэгтгэн тайлагнах,
- Орон нутгийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах (худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах), шинээр олж авах харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээ гаргах, орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид бүртгэлээр хяналт тавих, зөрчлийг арилгуулах,

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,423.8 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,005.1	-	(3,005.1)
Авлага	-	-	-
Бараа материал	1,571.9	444.5	(1,127.4)
Үндсэн хөрөнгө	1,396,182.7	1,457,739.0	61,556.3
Нийт хөрөнгө	1,400,759.7	1,458,183.5	57,423.8
Өр төлбөр	3,005.1	-	(3,005.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,397,754.6	1,458,183.5	60,428.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,400,759.7	1,458,183.5	57,423.8

Бараа материалын дансны үлдэгдэл 444.5 мянган төгрөг болж 1,127.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 12,099.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ОНӨГ-ын даргын 2024 оны А/03 тоот тушаалаар 1,347.4 мянган төгрөгийн аж ахуйн материалыг шилжүүлж, үйл ажиллагаанд 2,303.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,457,739.0 мянган төгрөг болж 61,556.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,450.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, худалдан авч, Дархан-Уул аймгийн ИТХурлаас 8,690.6 мянган төгрөг, Шарын голын ЗДТГазраас 8,300.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, Дархан-Уул аймгийн ИТХ-ын 27 дугаар тогтоолоор Тогтвортой амжиргаа төслөөс 3,323.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,162.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил,

Дархан-Уул аймгийн Засаг даргын 01-А/491 тоот захирамжаар Орон нутгийн хөгжлийг дэмжих төслөөрхи Шинэ хөдөө төслийн багц-2-аас 87,902.3 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө /хүлэмж, усалгааны систем/-ийг тус тус үнэ төлбөргүйгээр, ОНӨГ-ын даргын 2024 оны А/34 тушаалаар 13,500.0 мянган төгрөгийн Цагдаагийн газрын явуулын ажлын байрыг шилжүүлэн авч, ОНӨГ-ын даргын 2024 оны А/04 тушаалаар анхны өртгөө элэгдлээр бүрэн нөхсөн хөрөнгийг 4,460.2 мянган төгрөгөөр дахин үнэлж тус тус орлогоор бүртгэж, 48,477.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,458,183.5 мянган төгрөг болж мянган 57,423.8 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 501,072.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Тайлант онд батлагдсан төсвийг 25,813.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон, 526,885.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 526,885.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 422,555.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 191,800.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 230,754.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 403,344.8 мянган төгрөг буюу 76.6 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 278,125.2 мянган төгрөг 74.3 хувьтай, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 38,325.0 мянган төгрөг 81.9 хувьтай, тогтмол зардлаас 4,481.4 мянган төгрөг 35.8 хувьтай, бараа материалын зардлаас 11,473.5 мянган төгрөг 91.6 хувьтай ба орон нутгийн төсөвт 230,754.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70426-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	496,480.3	375,819.6	(120,660.7)	75.7%
2		80217-Мэдээлэл технологи	2,000.0	-	(2,000.0)	0.0%
3		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	28,405.1	27,525.2	(879.9)	96.9%
Нийт			526,885.4	403,344.8	(123,540.6)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 11 ажилтан буюу нийт 12 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,927.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Т.Эрдэнэтуяа гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Э.Эрдэнэбат, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 535,529.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,355.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 5 мэдээллийг хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тус цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүллээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн

гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 1,029.2 мянган төгрөгийн санхүүгийн тайлантай холбоотой 2 зөрчлийн биелэлтийг шалгахад зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1,029.2	2	1,029.2	100
Нийт дүн	2	1,029.2	2	1,029.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,500.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд Цагдаагийн газраас шилжүүлж авсан 13,500.0 мянган төгрөгийн явуулын ажлын байрыг үндсэн хөрөнгийн тайланд өөрийн хөрөнгөөр худалдан авснаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, _УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн тайланд шилжүүлж авсан хөрөнгөөр бүртгэж залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Мөн аудитаар нийт 111.6 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 111.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт байхгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

5.3.1. Материалын зарцуулалттай холбоотой асуудал

5.3.2.1 Илрүүлэлт: Тус газрын ахлах мэргэжилтэн Л.Баасанханд 3.1 мянган төгрөг, мэргэжилтэн Г.Жагдаг 108.4 мянган төгрөг ээлжийн амралтын цалинг илүү тооцож олгосон байна.

5.3.2.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж байх.

Дээрх зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.1, 4.4.2-т дурдсан хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Тайланд онд санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тайлангийн тодруулгад шилжүүлж авсан 13500.0 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан гэж тайлагнасан аудитын явцад залруулав.	1	13,500.0	-	-	-	-	1	13,500.0	-	-	-	-	-
Дүн	1	13,500.0	-	-	-	-	1	13,500.0	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус газрын ахлах мэргэжилтэн Л.Баасанханд 3,1 мянган төгрөг, мэргэжилтэн Г.Жагдаг 108,4 мянган төгрөг ээлжийн амралтын цалинг илүү тооцож олгосон байна.	1	111.6	-	-	-	-	1	111.6	-	-	-	-
Дүн	1	111.6	-	-	-	-	1	111.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 5 мэдээллийг хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
Тус цэцэрлэг нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-